




ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын компаниудын хувьцааны ханш өмнөх долоо хоногийн уналтаас сэргэн эерэг үзүүлэлттэй байлаа. Nasdaq индекс хамгийн ихээр өсөн, энэ Баасан гарагт өдрийн хамгийн өндөр үзүүлэлтийг тогтоосон. S&P 500 индексийн мэдээлэл технологи, санхүү, аж үйлдвэрлэл болон бизнесийн үйлчилгээ үзүүлэгч компаниудын хувьцааны ханш өссөн бол өргөн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш буурсан байна.

АНУ-ын Хөдөлмөрийн яам хөдөлмөр эрхлэлтийн талаарх судалгааны тайланг танилцуулсантай холбоотойгоор АНУ-ын зах зээлийн индексүүд энэ 7 хоногт өсжээ. Тус тайлангаас харахад 2-р сард ажил олгогчид ажлын байрыг хүлээгдэж байснаас илүү нэмсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийн тайлангийн эерэг үзүүлэлтүүд урт хугацаат бондын өгөөжийг нэмсэн.

Ган болон хөнгөн цагааны импортын шинэ тариф нь олон улсыг хамарсан худалдааны дайнд хүргэж болзошгүй гэсэн таамаг энэ долоо хоногийн зах зээлийн өсөлтийн сааруулжээ. Европ болон Азийн орнууд энэ 7 хоногийн эхээр тус арга хэмжээнд ямар нэгэн хариу мэдэгдэл хийгээгүй учир худалдааны дайны талаарх асуудал намжсан байна. Пүрэв гарагийн үдээс хойш Ерөнхийлөгч Трамп тус тарифаас Канад, Мексик улсыг түр хугацаагаар чөлөөлсөн бөгөөд бусад худалдааны түншүүдийг тус тарифаас чөлөөлөх боломжтой хэмээн мэдэгдсэн.

Канад: Ерөнхийлөгч Трамп Канад болон Мексик улсыг ган, хөнгөн цагааны тарифаас чөлөөлсөн тухай мэдэгдэл хийснээс хойш Канадын S&P/TSX индекс 1.26 хувиар өсөж 15,577.81 хүржээ.

Европ: Европын томоохон индексүүд энэ 7 хоногт эерэг үзүүлэлттэй байлаа. Зөвхөн Германы DAX 30 индекс буурсан байна. Германулс гангаар хийсэн бүтээгдэхүүн, ган авто машин болон машин механизмын томоохон экспортлогч бөгөөд шинэ тарифтай холбоотойгоор ийнхүү DAX 30 индекс буурчээ. Европын STOXX 600, Их Британий FTSE 100, Францын CAC 40 индексүүд энэ 7 хоногт өсжээ.

Япон: Японы хувьцааны индекс энэ 7 хоногийн турш тогтворгүй байсан ч өссөн үзүүлэлттэй байлаа. Nikkei 225 индекс 1.4% өсөн 21,469.20 нэгж болж хаагдсан. Иений ханш ам. долларын эсрэг суларч 106.85 болсон нь 2017 оны сүүлч буюу 112.7-гоос доогуур байна.

Хятад: Хойд Солонгосын удирдагч Ким Чен Ун болон АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп хоорондын эерэг хамтын ажиллагааны талаарх хүлээлттэй холбогдуулан Хонг Конгийн хувьцааны ханш өссөн байна. Hang Seng индекс 1.35 хувиар өсч 30,996.21 нэгж хүрсэн. Hang Seng индексийн эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш 0.9 хувиар, мэдээлэл технологийн салбар 1.19 хувиар, санхүүгийн салбар 0.9 хувиар, үл хөдлөх хөрөнгийн салбар 0.95 хувиар өсжээ.

Эх сурвалж: Reuters.com, Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,800.77	6.04%▲
Dow Jones	АНУ	25,335.74	3.25%▲
S&P 500	АНУ	2,786.57	3.54%▲
Nasdaq	АНУ	7,560.81	4.17%▲
S&P/TSX	Канад	15,577.81	1.26%▲
FTSE 100	Их Британи	7,224.51	2.19%▲
S&P/ASX 200	Австрали	5,963.20	0.58%▲
Nikkei 225	Япон	21,469.20	1.36%▲
Hang Seng	Хонг Конг	30,996.21	1.35%▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	113.77
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	99.56
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	98.54
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	116.37
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.48
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.88
TDBM' 2020	USD	9.3%	108.58

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	YoY
Libor 1M	1.750	0.06▲
Libor 3M	2.089	0.06▲
Libor 6M	2.269	0.04▲
Libor 1YR	2.545	0.05▲
US 6M Bond	1.865	0.03▲
US 2YR Bond	2.266	0.04▲
US 3YR Bond	2.436	0.07▲
US 5YR Bond	2.660	0.06▲
US 10YR Bond	2.901	0.06▲

Валютын ханш /төг/

Валют	2018.03.09	Өөрчлөлт
USD	2,394.77	0.04%▲
CNY	378.03	0.28%▲
EUR	2,949.16	0.45%▲
RUB	41.99	-0.64%▼
KRW	2.24	0.90%▲
JPY	22.45	-0.84%▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,323.93	0.13%▼
Мөнгө /spot/	16.59	0.61%▲
Зэс	3.1367	1.15%▼
Нүүрс	93.87	4.99%▼
WTI газрын тос	2.04	1.29%▲
Brent газрын тос	65.49	1.74%▲
Байгалийн хий	2.73	1.11%▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляций түвшин	2018.I	6.90%
Бодлогын хүү	2018.I	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.I	13.63%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018.I	12.50%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.I	5.80%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018.I	19.40%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.I	10.80%

Эх сурвалж: Үндэсний статистикий хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 44 компанийн 339.8 сая төгрөгийн 506,298 ширхэг хувьцаа арилжигдав.

“Дархан зочид буудал” /DZG/ компанийн хувьцаа 31.06%-аар буюу хамгийн ихээр өсч 173 төгрөгт хүрч хаагдсан бол “Бөөний худалдаа” /BHL/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 425 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээлд арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 7 удаагийн хэлцлээр 11,773 ширхэг үнэт цаас 1,216 сая төгрөгөөр арилжаалагдлаа.

Харин компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр энэ долоо хоногт арилжаа хийгдээгүй байна.


3-р сарын 09-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,513.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,800.77 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 6.04%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: MSE

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,556
Зах зээлийн үнэлгээ	2,513,300

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20*	20,800.77	6.04% ▲
MSE I индекс	10,319.88	8.51% ▲
MSE II индекс	9,865.25	0.99% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
АПУ	194,770	131,464,608
Тавант Толгой	6,871	74,946,890
Говь	1,693	39,800,440
Сүү	45,797	25,169,439
Монгол Шуудан	54,617	12,316,023

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Дархан зочид буудал	173.00	31.06% ▲
Таван Толгой	11,010.00	15.53% ▲
Айтүүлс	140.00	15.28% ▲
Евроазиа капитал холдинг	580.75	15.00% ▲
Дархан гурил тэжээл	517.51	15.00% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Бөөний худалдаа	425.00	-15.00% ▼
Бөхөг	4,100.00	-12.77% ▼
Авто зам	4,125.00	-12.42% ▼
Монгол нэхмэл	4,850.00	-11.74% ▼
Материалимпекс	9,500.00	-10.38% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
БиДиСек	156,658,284
Голомт Капитал	93,799,635
Ти Ди Би Капитал	75,936,189
Стандарт инвестмент	64,497,718
Гендекс	44,774,186

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	688.47	732,657
Таван толгой	11,010.00	579,844
МИК	10,000.00	207,093
Говь	24,000.00	187,227
Сүү	249.32	85,766

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Үнэ /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Үнэ /төг/	7 хоног	Хүү
1	ZBEG-BD-15/08/20-A0295-14.5	200	19,996,000	99,980	156	14.500
2	ZBEG-BD-15/08/20-A0295-14.5	48	5,047,200	105,150	156	14.500
3	ZBEG-BD-15/08/20-A0295-14.5	152	16,146,960	106,230	156	14.500
4	ZBEG-BD-20/06/20-A0260-15.14	460	49,266,000	107,100	156	15.140
5	ZBEG-BD-25/04/20-A0236-16.993	500	55,055,000	110,110	156	16.993
6	ZBEG-BD-26/09/19-A0326-13.955	1,692	170,215,200	100,600	104	13.955
7	ZBEG-BD-26/09/19-A0326-13.955	1,692	176,154,120	104,110	104	13.955
8	ZBEG-BD-27/03/20-A0225-18	1,200	129,408,000	107,840	156	18.000
9	ZBEG-BD-27/03/20-A0225-18	1,200	133,932,000	111,610	156	18.000
10	ZBEG-BD-29/08/19-A0305-14	66	6,642,900	100,650	104	14.000
11	ZBEG-BD-29/08/19-A0305-14	66	8,864,000	104,000	104	14.000
12	ZBEG-BD-18/07/20-A0275-15.14	500	50,000,000	100,000	156	15.140
13	ZBEG-BL-20/03/18-A0221-0	1,997	198,322,070	99,310	52	17.613
14	ZBEG-BL-20/03/18-A0221-0	2,000	199,420,000	99,710	52	17.613

Компанийн бондын арилжаа / хоёрдогч зах зээл /

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан дүн	Үнийн дүн /төг/	Үнэ /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД


№	Симбол	Компанийн нэр	Нийт ногдол ашиг /сая төг/	Нэгж хувьцаанд ногдох ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	AEL	Анд-Энерги ХК	13.3	0.5	2018.02.24	2018.03.16	N/A
2	SUL	Жуулчин дүти фрий ХК	653.6	10,000.0	2018.02.23	N/A	2018.05.01-ээс
3	SUU	Сүү ХК	1,032.0	3.0	2018.02.14	N/A	2018.12.31-ний дотор
4	GTL	Гутал ХК	2,055.7	1,270.0	2018.02.19	N/A	2018.07.06-аас
5	BNG	Баянгол Зочид буудал ХК	150.2	355.0	2018.02.19	N/A	2018.09.01-ээс
6	APU	АПУ ХК	10,641.8	10.0	2018.02.19	N/A	2018.06.01-ний дотор
7	BTG	Баянтээг ХК	25.3	100.0	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
8	MIE	Материалимпекс ХК	13.7	10.0	2018.02.19	2018.03.26	2018.12.31-ний дотор
9	MNP	Монгол шуудан ХК	273.5	2.7	2018.02.13	N/A	2018.05.01-ээс
10	MMX	Махимпекс ХК	380.1	100.0	2018.02.13	2018.04.05	2018.10.01-ээс
11	TCK	Талх чихэр ХК	174.0	170.0	2018.02.12	2018.04.06	2018.07.01-ээс
12	ADL	Адуун чулуун ХК	409.7	130.0	2018.02.07	2018.03.01	N/A
13	TAN	Тахь-ко ХК	128.1	108.0	2018.02.05	N/A	2018.05.01-ний дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

МХБ: “Лэндмн ББСБ” ХК-ийн 75 мянган төгрөг хүртэлх захиалга 100 хувь биелэх боломжтой

Нийт таван тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр IPO гаргасан “Лэндмн ББСБ” ХК-ийн анхдагч зах зээлийн захиалга 43.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнээс 2.5 тэрбум төгрөг нь стратегийн хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө. Харин 41.3 тэрбум төгрөг нь олон нийтээс авсан захиалга гэж “Mirae Asset Securities Mongolia” үнэт цаасны компани мэдээллээ. Ийнхүү захиалагчдын тоо 6000 давснаар, 75 мянган төгрөг хүртэлх захиалгыг 100 хувь биелүүлэхээр болсон байна. Харин илүү гарсан мөнгөн дүнд хувь тэнцүүлж хувьцааг хуваарилах талаар андеррайтер компани нь мэдээллээ. Хамгийн сүүлд “Айтүүлс” ХК-ийн захиалга нийлүүлэлтээсээ гурав дахин давж түүхэн амжилт үзүүлж байсан. Харин энэ удаа МХБ-ийн III ангилалд бүртгүүлж байгаа “Лэндмн ББСБ” ХК-ийн захиалга нийлүүлэлтээсээ 16.5 дахин давлаа. Шинэ бүтээгдэхүүн хөрөнгийн зах зээлд гарахын зэрэгцээ иргэдийн хувьцааны талаарх ойлголт нэмэгдэж байгааг МХБ мэдээллсэн. Мөн хөрөнгийн зах зээлд оролцох иргэдийн идэвх нэмэгдсэн нь “Лэндмн ББСБ” ХК-ийн захиалгад нөлөөлжээ. Одоо СЗХ-оос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон талаар шийдвэр гаргахыг хүлээж буй. Энэ шийдвэр гарсны дараа иргэд биелэгдээгүй захиалгынхаа мөнгийг буцаан авах боломжтой гэдгийг МХБ мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



“Могойн гол” ХК-ийн борлуулалтын орлого 2017 онд 2.5 тэрбум төгрөг болж, 31 хувиар өсжээ

МХБ-ийн II ангилалд бүртгэлтэй “Могойн гол” ХК-ийн борлуулалтын орлого 2017 онд 2.5 тэрбум төгрөг хүрч, 2016 оныхоос 31 хувиар өсжээ. Мөн нүүрсний олборлолт 20 хувиар нэмэгдэж, 100 мянган тонн хүрсэн байна. Үүнээс 74900 тонн нүүрс борлуулсан байна. “Могойн гол” ХК-иас нүүрс худалдан авч БНХАУ-ын зах зээлд нийлүүлж байгаа дөрвөн компани бий. Тэдний хувьд, 2017 онд нийт 18 мянган тонн нүүрс Хятадын зах зээлд гаргасан нь 2017 оны борлуулалтын орлого өсөхөд нөлөөлжээ. Үүнээс гадна компанийн ерөнхий ба удирдлагын зардал бага зэрэг буюу 19 хувиар нэмэгдэж, 196 сая төгрөг болсон байна. Компани 2017 оны эцэс гэхэд 245.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, энэ үзүүлэлт өмнөх оныхоос 2.2 дахин нэмэгдсэн талаар МХБ мэдээллсэн. Хөвсгөл аймгийн нутагт Могойн гол ордод чулуун, хүрэн нүүрсний олборлолт хийдэг тус компани нь Хөвсгөл аймгийн болон хил залгаа Завхан аймгийг нүүрсээр ханган ажилладаг. Компанийн хувьд, өнгөрсөн нэг жилийн хугацаанд хувьцааны ханш нь тав орчим хувиар өсөж, өнөөдрийн байлаар 8000 төгрөгөөр хувьцааг нь арилжаалж байна. Хамгийн сүүлийн байдлаар компанийн зах зээлийн үнэлгээ 6.6 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна. Ямартай ч “Могойн гол” ХК 2018 онд 100 мянган тонн нүүрс олборлож, 80 мянган тонн нүүрс борлуулахаар төлөвлөжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



АПУ ХК 24.87 тэрбум төгрөг буюу нэгж хувьцаандаа 23.4 төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ

Хөрөнгийн зах зээлийн хамгийн өндөр үнэлгээтэй АПУ компанийн цэвэр ашиг 2017 онд 24.87 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 8.7 дахин өслөө. Харин борлуулалтын орлого нь 12.8 хувиар өссөн гэж санхүүгийн тайландаа тусгажээ. Тайланг харвал 2016 онд гадаад валютын ханшийн зөрүүнээс 26.5 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж байсан бол 2017 онд 2.4 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Харин ерөнхий ба удирдлагын зардал жилийн дүнгээр зургаан тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Тус компани цэвэр ашгийнхаа 42.8 хувийг буюу нийт 10.6 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар болсноо энэ оны хоёрдугаар сард зарласан байна. Энэ нь тус компанийн хувьцаа эзэмшигчдэдээ олгож байгаа хамгийн их хэмжээний ногдол ашиг болж байгаа юм. АПУ компанийн хувьцааны ханш “Heineken International”-тэй нэгдэн, нийлэх хэлцэл батлагдсанаас хойш өнөөг хүртэл 28.5 хувиар унаад байгааг Монголын Хөрөнгийн бирж мэдээллээ. Нэгдэн нийлэх үйл ажиллагааны бэлтгэл хоёр жил үргэлжилжээ. Улмаар 2017 оны наймдугаар сард АПУ компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэмжиж, аравдугаар сард Монголын Хөрөнгийн бирж зөвшөөрөл гаргаж, 11 дүгээр сард Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрснөөр АПУ ХК-ийн үнэт цаасанд өөрчлөлт орсон байна. Дэлхийн 70 гаруй оронд 165 үйлдвэртэй “Heineken” компани АПУ компанийн хувьцааны 25 хувийг эзэмшиж байгаа юм. Энэхүү хэлцлийн дүнд АПУ компани экспортоо тэлж, олон улсын зах зээлд гарах боломж бүрдэнэ гэж таамаглаж байгаагаа мэдэгдэж байсан юм. Мөн энэ нь “Шингэн хүнс үйлдвэрлэлийн шилдэг ноу-хауг нэвтрүүлж, үйл ажиллагааны ашигт байдлыг сайжруулна” гэж АПУ компани мэдэгдэлдээ дурдаж байв.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Хай Би Ойл” ХК-ийн борлуулалтын орлого 23.6 хувиар өсөж, 561.4 сая төгрөгт хүрэв

Монголын Хөрөнгийн биржийн II ангилалд бүртгэлтэй “Хай Би Ойл” ХК-ийн борлуулалтын орлого 2017 онд 23.6 хувиар өсөж, 561.4 сая төгрөгт хүрсэн байна. Тус компанийн санхүүгийн тайланг харвал 2017 онд ерөнхий ба удирдлагын зардлаа 6.7 дахин бууруулж, 298.3 сая төгрөг болгосон байна. Хэдий тийм боловч 2016 онд үйл ажиллагааны бус зардал нь 5.5 сая төгрөг байсан бол 2017 онд энэ нь 3.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Улмаар санхүүгийн жилийн эцэс гэхэд “Хай Би Ойл” ХК-ийн алдагдал 2.6 дахин нэмэгдэж, 3.69 тэрбум төгрөг болжээ. Тус компани газрын тосны хайгуул олборлолт, дахин боловсруулалтын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа аж. Хувьцааны арилжааг нь харвал өнгөрсөн нэг жилийн хугацаанд “Хай Би Ойл” ХК-ийн хувьцааны ханш 2.3 дахин буурч, өнөөдрийн байдлаар 68.56 орчим төгрөгт хүрээд байна. Тус компанийн зах зээлийн үнэлгээ 3.6 тэрбум төгрөг болоод байгаа талаар Монголын Хөрөнгийн бирж мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



“Mongolian Metals Corporation”, “Steppe Gold” компаниуд хувьцаагаа арилжаалах сонирхолтой байна

Монголд уул уурхайн салбарт хайгуул хийж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын хувьцааны арилжаатай холбоотой томоохон хөдөлгөөн гарч байна. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт төвлөрдөг Торонтогийн Хөрөнгийн биржид “Mongolian Metals Corporation”, “Steppe Gold” компаниуд хувьцаагаа арилжаалах сонирхолтой байгаагаа илэрхийллээ. “Steppe Gold” компани өнгөрсөн оны эхээр IPO гаргах тухай ярьж эхэлсэн. Компани 2017 онд Монгол дахь хайгуулын төслүүдээ идэвхжүүлсэн. Тухайлбал “Centerra Gold” компаниас “Алтан цагаан овоо” алтны хайгуулын төслийн тусгай зөвшөөрлийг 9.8 сая ам.доллараар худалдаж авсан бөгөөд энэ хэлцлийг эцэслэсэн. Мөн энэ төслийн талбайд 4000 метрийн өрөмдлөг хийсэн. Үүнээс гадна Баянхонгор аймгийн нутагт байрлах “Уудам хөндий” нэртэй хайгуулын төслийг худалдан авч, орон нутгийн засаг захиргаатай 80/20 гэсэн харьцаатайгаар хамтран хөрөнгө оруулсан. Тус төслийн талбай дахь эхний шатны хайгуулын ажлыг гүйцэтгэж, алтны дөрвөн шинэ илэрц бүхий хэсгийг илрүүлсэн гэж компани мэдэгдсэн юм. Мөн 2017 онд 45 сая канад долларын санхүүжилт татсан “Steppe Gold” компани Торонтогийн Хөрөнгийн биржид бүртгүүлэх ажлаа эхэлсэн. Харин “Mongolian Metals Corporation” сүүлийн 12 жилийн хугацаанд Монголд хайгуулын 13 лиценз худалдаж авсан. Үүнээс одоогоор хоёр тусгай зөвшөөрөл нь үлджээ. Баянхонгор аймгийн нутагт байрлах нийт 75 мянган гектар газрыг хамарсан эдгээр талбайд сүүлийн 8,9 жил идэвхтэй хайгуул хийж байгаа юм. Харин өнгөрсөн онд алт, зэс, мөнгөний сайн илэрцүүд олсон гэдгээ компанийн тэргүүн онцолсон. Торонтогийн Хөрөнгийн биржид бүртгүүлэхээр бэлтгэж байгаа. Одоогоор үүний бэлтгэл ажил болон хайгуулын төслүүдээ зарцуулахаар нэг сая ам.долларын хөрөнгө босгож байгаа юм. Харин IPO хийх үеэр 3-5 сая ам.долларын хөрөнгө татна гэж компани найдаж байна.

Үүнээс гадна Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Xanadu Mines” компани мөн Торонтогийн Хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийллээ. Компанийн хайгуулын гол орд нь Өмнөговь аймгийн нутагт байрлах Хармагтай төсөл юм. 2015 онд хайгуулын ажлыг идэвхжүүлсэн. Цаашид амжилттай үргэлжлүүлэхэд шаардлагтай 9.1 сая австрали долларын бэлэн мөнгөний нөөц компанид байна. Үүнээс 3.4 сая австрали долларыг зөвхөн I улиралд зарцуулахаар төлөвлөж байгаа юм. Монголын Хөрөнгийн бирж давхар бүртгэлийн журмыг батлаад удаагүй байгаа. Үүнтэй холбоотойгоор Торонтогийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Erdene Resource Development”-ийн хувьд, Монголын Хөрөнгийн биржид давхар бүртгүүлж магадгүй тухай эх сурвалжууд өмнө нь мэдээлж байсан. Гэхдээ одоогоор албан ёсны мэдэгдэл гаргаагүй байгаа юм. Компани “Баян хөндий”, “Алтан arrow”, “Алтан нар” ордуудад идэвхтэй хайгуулж хийж байгаа бөгөөд хайгуулын явц сайн байгааг мэдээлсэн.

Эх сурвалж: BloombergTV.mn

Saudi Aramco: Газрын тос, байгалийн хийн салбарт 20 их наяд ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай

Ойрын 25 жилд дэлхийн газрын тос, байгалийн хийн салбарт 20 их наяд ам.долларын хөрөнгө оруулалт хийх шаардлагатай болно гэж “Saudi Aramco” компанийн Гүйцэтгэх захирал Амин Нассер мэдэгдлээ. 2014-2016 онд газрын тосны ханш буурсны улмаас энэ салбар нэг их наяд ам.долларын хөрөнгө оруулалтаа алдсан байна. Тиймээс ирээдүйд газрын тосны эрэлт тасрахгүйг ойлгож, хөрөнгө оруулагчдыг эргэж татах нь маш чухал байгааг Амин Нассер онцолжээ.

Тэрбээр цахилгаан автомашины зах зээл тэлж байгаа ч ойрын 20 гаруй жилд шатахууны зах зээлийн эрэлт өсөх тул энэ салбарт нэмэлт хөрөнгө оруулалт шаардагдана гэж үзэж байгаа аж. Суудлын автомашинуудын 99 хувь нь дотоод шаталтат хөдөлгүүртэй бөгөөд хосолмол хөдөлгүүртэй автомашинууд ч багтаж байгаа юм. Мөн зайгаар явдаг автомашинуудын цахилгаан үүсгүүрт нүүрсийг түлхүү ашиглаж байгаа хэвээрээ байгаа аж. Ялангуяа Энэтхэг, БНХАУ-ын зах зээлд ийм байгаа гэдгийг “Saudi Aramco”-ийн Гүйцэтгэх захирал онцоллоо.

Мөн тэрбээр “Saudi Aramco”-ийг нээлттэй компани болохоор төлөвлөж байгааг хэлсэн юм. Тус компанийн хувьцааг олон нийтэд арилжаалах эсэхийг тус компанийн хувьцааны таван хувийг эзэмшигч Саудын Арабын Засгийн газар шийдвэрлэх болно.

Эх сурвалж: BloombergTV.mn



2018 он: Хятад ган үйлдвэрлэлээ 30 сая тонноор танана

Хятадын Засгийн газраас 2018 онд дотоодын гангийн үйлдвэрлэлээ 30 сая тонн, нүүрсний үйлдвэрлэлийг 150 сая тонноор тус тус танахаар төлөвлөж байна. Энэхүү төлөвлөгөө нь тус улсын агаарын бохирдлыг бууруулах зорилтоос гадна хүнд үйлдвэрийн илүүдэл хүчин чадлыг танах, хуучирсан үйлдвэрүүдийг хаах бодлогын хүрээнд хийгдэж байгаа юм. Өнгөрсөн онд Хятад улс нь гангийн үйлдвэрлэлээ 50 сая тонн, нүүрснийхийг 150 сая тонноор танасан юм.

Хэдийгээр Хятадын Засгийн газраас агаарын бохирдолтой тэмцэх зорилтыг 2013 оноос дэвшүүлэн хэрэгжүүлж байгаа ч сүүлийн таван жилд анх удаа тус улсын нүүрсний хэрэглээ өсчээ. Тодруулбал, 2017 онд нүүрсний дотоодын хэрэглээ 0.4%-иар өссөнийг тус улсын Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн байна. Энэхүү өсөлт нь 2017 оны аравдугаар сард зохион байгуулагдсан Коммунист намын XIX хуралтай холбоотой гэж шинжээчид үзэж байна.

Хятадын Засгийн газраас агаарын бохирдолтой тэмцэх зорилтыг өнгөрсөн таван жилд хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор хүнд үйлдвэрийн салбар дахь шинэчлэлийн зорилт, хэрэгжилтийн явцын талаар БНХАУ-ын Төрийн зөвлөлийн дарга Ли Кэцян өнөөдөр нээгдсэн Ардын төлөөлөгчдийн их хурлын үеэр илтгэл тавьсан юм.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

БУСАД МЭДЭЭ

Инфляц Төв банкны зорилтот найман хувьтай ойролцоо түвшинд хадгалагдаж магадгүй байна

"Bloomberg"-ийн эдийн засагчдын клубийн шинжээчдийн таамаглаж байгаагаар инфляц энэ онд Төв банкны зорилтот найман хувьтай ойролцоо түвшинд хадгалагдаж магадгүй байна. Тухайлбал, энэ оны эхний улиралд инфляц долоо орчим хувьтай гарна гэж дийлэнх шинжээчид тооцоолжээ. Харин бүтэн жилээр авч үзвэл инфляц нэг оронтой тоонд хадгалагдана гэсэн таамаг давамгайлж байгаа юм. Монгол Улсын инфляц 2017 онд эрчимжиж, зорилтот түвшинд ойртсон хэдий ч цаашид мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн зорилттой нийцтэйгээр тогтворжих төлөвтэй гэж Монголбанк үзэж байна. Архи тамхи, шатахуун зэрэг зарим бүтээгдэхүүний онцгой албан татвар нэмэгдсэн энэ оны нэгдүгээр сарын байдлаар инфляц 6.9 хувьтай гарсан юм. Харин Улаанбаатар хотын инфляц зорилтот найман хувьд хүрээд байгааг Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Үүнд орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 16.7 хувь, тээврийн хэрэгслийн худалдан авалтын дэд бүлгийн үнэ 24.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 9.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Улаанбаатар хотод энэ оны нэгдүгээр сард хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 31.1 хувийнх нь үнэ өмнөх сараас өссөн байна. Судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн барааны 51 нэрийн барааны үнэ нэмэгдээд байгаа аж. 2018 онд ээсийн баяжмал дахь металлын агууламж сайжрах, хөрөнгө оруулалт нэмэгдэх дам нөлөөгөөр уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл идэвхжихээр байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжинэ гэж Төв банк үзэж байна. Мөн сүүлийн жилүүдэд саараад байсан гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх төлөв ажиглагдаж байгаа юм. Тухайлбал, 2018 онд нэг тэрбум орчим ам.доллартай тэнцэх мөнгө эдийн засагт орж ирэх хүлээлттэй байгаа талаар Монголбанкны Ерөнхийлөгч мэдээлж байлаа.

Эх сурвалж: BloombergTV.mn

Credit Suisse: Японы эдийн засгийн өсөлт саарах эрсдэлтэй байна

Японы эдийн засгийн өсөлт I улиралд саарах эрсдэлтэй байгааг "Credit Suisse"-ийн шинжээчид онцоллоо. Иенийн ханш чангарснаас гадна олон улсад худалдааны дайн дэгдэх эрсдэл бий болсон нь үүнд нөлөөлжээ. Японы эдийн засаг өнгөрсөн оны IV улиралд 1.6 хувиар буюу найм дахь улиралдаа дараалан өссөн байна. Энэ нь сүүлийн 30 жилд байгаагүй эерэг үзүүлэлт болсон ч I улиралд энэ байдал өөрчлөгдөхөөр байгаа аж. Дэлхийн гуравдагч том эдийн засагтай Япон улсад цалингийн түвшин дорвитой өсөхгүй байгаа нь хэрэглэгчдийн зарцуулалт нэмэгдэхгүй эрсдэл бий болгожээ. Мөн иенийн ханш чангарсан нь компаниудын санхүүгийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлөхийн дээр компани, хэрэглэгчдийн эдийн засагт итгэх итгэлийг бууруулж байна гэж шинжээчид тайлбарлаж байна. Энэ нь инфляцыг хоёр хувьд хүргэх зорилтоо биелүүлэхэд ойртсон Японы Төв банкны хувьд таагүй мэдээ боллоо.

Эх сурвалж: BloombergTV.mn

Хөнгөн цагаан, гангийн импортод гаалийн тариф тогтоох шийдвэрт Дональд Трамп гарын үсэг зурлаа

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп ган болон хөнгөн цагааны импортод гаалийн тариф тогтоох шийдвэрт гарын үсэг зурлаа. Ийнхүү тэрбээр кампанит ажлынхаа үеэр өгсөн амлалтаа биелүүлснээр АНУ гуравдугаар сарын эхээр зарлаж байсанчлан гангийн импортод 25 хувь, хөнгөн цагааны импортод 10 хувийн гаалийн татвар ногдуулахаар боллоо. Энэхүү шийдвэр 15 хоногт багтан хэрэгжинэ гэж Цагаан ордон мэдэгджээ. Гаалийн тариф тогтоох шийдвэрт Мексик болон Канад улсыг багтаагаагүй байна. Учир нь Дональд Трамп Хойд Америкийн чөлөөт худалдааны хэлэлцээрийг эргэн харахыг зорьж байгаа гэж ажиглагчид тайлбарлаж байна. "Миний бие АНУ-ын үндэсний аюулгүй байдлыг хамгаалахын тулд ган, хөнгөн цагааны импортод татвар ногдуулахаар шийдвэрлэлээ" гэж Дональд Трамп салбарын төлөөлөлтэй уулзахдаа мэдэгджээ. АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп "Шударга бус худалдаа зөвхөн эдийн засгийн аюул биш. Энэ нь үндэсний аюулгүй байдалтай холбоотой. Бид өөрийн улсад үйлдвэрлэсэн ган, хөнгөн цагаанаар нисэх болон хөлөг онгоц, батлан хамгаалахын зэвсэг техник, тоног төхөөрөмж үйлдвэрлэхийг зорьж байна. Эцэст нь бид урт хугацааны турш асуудал үүсгэж байсан худалдааны нөхцөлийг зөв замд нь чиглүүлэх арга хэмжээг авч байна. Бусад улсуудын худалдааны түрэмгий бодлого АНУ-ын ган болон хөнгөн цагааны үйлдвэрлэлд асар их хохирол учруулсаар ирсэн. Энэ зовлонг АНУ-ын үйлдвэрлэгчид хэн бүхнээс илүүтэй мэдэрсэн. Тиймээс бид шударга худалдаа хийхийг хүсэж байна" гэж мэдэгдсэн байна. Дээрх шийдвэрийг батлахаас өмнө Дональд Трампын засаг захиргаа АНУ-тай хийж буй худалдааны алдагдлыг бууруулахыг БНХАУ-ын талаас хүссэн гэсэн мэдээлэл гарсан байна.

БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И "Худалдааны дайн асуудлын зөв шийдэл биш" гэж байр сууриа илэрхийлжээ. Тэрбээр "Даяаршсан дэлхий ертөнцөд худалдааны дайн эхлүүлэх нь аль аль талдаа эрсдэл учруулах, ашиггүй үйлдэл" гэж үзэж байгаа аж. Түүнчлэн БНХАУ ашиг сонирхлоо хамгаалахын тулд "Хүчтэй хариу арга хэмжээ авна" гэдгийг анхааруулжээ. Ван И "БНХАУ зүй ёсны, шаардлагатай хариу арга хэмжээ авна. Дэлхийд эдийн засгаараа хоёрдугаарт бичигддэг улсын хувьд БНХАУ болон АНУ-ын ашиг сонирхол харилцан хамаарал ихтэй. Тийм учраас бидний хувьд зөвхөн өөрийн улсын гэлтгүй, дэлхий дахины сайн сайхныг хангахыг зорих ёстой. Манай хоёр улс хэлэлцээний ширээний ард сууж, үр дүнтэй хэлэлцээ хийж, аль аль талдаа харилцан ашигтай шийдэлд хүрнэ гэдэгт бид найдаж байна" гэж мэдэгдлээ.

Ийнхүү дэлхийд эдийн засгаараа тэргүүлэгч хоёр улсын харилцаа худалдааны салбараар хязгаарлагдалгүй улам хурцдаж байгааг олон улсын ажиглагчид онцолж байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.